



Монгол улс, ЭГЭЭББ судалгааны төслийн санал, дүгнэлтийн хураангуй

Мокоро байгууллагын практик, үйл ажиллагаанд суурилсан үрт хугацааны стратегитайгаар гүйцэтгэж буй Эмэгтэйчүүдийн газар эдэлбэрийн эрхийн баталгаат байдал (ЭГЭЭББ) судалгааны төсөл нь “Монгол болон Танзани улсад эмэгтэйчүүдийн газар эдэлбэрийн аюулгүй байдалд учрах эрсдлийг судлах” судалгааны арга зүйг түршиж байгаа юм. Монгол улс дахь Хүн Төвтэй Байгаль Хамгаалал ТББ-тай хамтран уул уурхайн хөрөнгө оруулалтын нөлөөлөлд өртсөн бэлчээрийн газар нутаг дахь эмэгтэйчүүдийн газар эдэлбэрийн баталгаат байдал ямар байгааг танадан судалж, эмэгтэйчүүдийн болон нийгмийн эмзэг бүлгийн газрын эрхэд учруулах гол аюулуудыг тогтоохын тулд хамтын оролцооны болон тоон судалгааны аргын аль альныг нь ашиглан судалгаа хийж байна. ЭГЭЭББ төслийн зорилго нь газар эдэлбэрийн засаглал дахь жендерийн эрх тэгш байдал, эмзэг бүлгийнхний газрын эрхийн баталгаат байдлыг сайжруулах, нутгийн иргэдийн газар, байгалийн нөөцөд учирж буй аюулаас хамгаалан, дэмжих боломжийг судлах юм.

Энэхүү судалгааны санал, дүгнэлтийн хураангуйд 2016 оны 4-р сараас 11-р сарын хооронд Дорноговь аймгийн Даланжаргалан, Төв аймгийн Борнуур сумдад тус тус хийгдсэн газартай танилцах аялал, суурь судалгаа, оролцооны аргын судалгаа зэрэг ажлын үр дүнг харуулж байна. Судалгаанаас гарсан эхний үр дүнг 2017 оны 6, 8 р саруудад сумдад танилцуулж, баталгаажуулсан. Судалгааны ажлын түрш биднийг дэмжиж, хамтран ажилласан Даланжаргалан, Борнуур сумдын захиргаадад гүнээ талархаж байна. Түүнчлэн ярилцлага, хэлэлцүүлэгт оролцож, бидэнд Монгол улс дахь жендер, газар, бэлчээрийн мал аж ахуй, уул уурхайн байдлын талаар ойлгож, мэдэж авахад дэмжлэг үзүүлсэн хүн бүрт талархалаа илэрхийлье.

Суурь судалгааны арга

Бид 2016 оны 8-р сард суурь судалгаа хийж сум бүрийн нийт өрхийн 10% ийг хамруулсан. Борнуурын сумын 142 өрх, үүнээссанамсаргүй түүврийн аргаар сонгосон 111 өрх, өрх толгойлсон эмэгтэйтэй 31 өрхийг нэмж судалгаанд хамруулсан. Даланжаргалан сумын 93 өрх, үүнээс санамсаргүй түүврийн аргаар сонгосон 74 өрх, өрх толгойлсон эмэгтэйтэй 19 өрхийг нэмж судалгаанд хамруулсан. Энэ нь Борнуурын сумын судалгааны түүврийн 78%, Даланжаргалан сумын судалгааны түүврийн 80% (Борнуурын 82 эрэгтэй тэргүүнтэй, 29 өрх толгойлсон эмэгтэйтэй өрх, Даланжаргалан сумын 57 эрэгтэй тэргүүнтэй, 17 өрх толгойлсон эмэгтэйтэй өрх багтана) санамсаргүй түүврийн аргаар, Борнуурын 22%, Даланжаргалангийн 20% нь зориудаар сонгож авсан өрх болж байна. Энэ нь судалгаанд өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийг олноор хамруулж жендер, эмзэг бүлгийнхний асуудлыг илүү тодорхой мэдэж авах гэсэн арга байлаа. Нэмж судалгаанд хамруулсан өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийн мэдээллийг зөвхөн эрэгтэй, эмэгтэй тэргүүнтэй өрхийн харьцуулсан дүн шинжилгээ, мөн эрэгтэй, эмэгтэй хариулагчийн дүн шинжилгээ хийхэд ашиглаж, суурь судалгааны бүх ерөнхий шинжилгээнд ашиглаагүй болно.

Оролцооны судалгааны арга

Оролцооны аргын судалгаа 2016 оны 11-р сард явагдсан ба 14 зорилтот бүлгийн үүлзалт (ЗБУ), 11 хувь хүний ярилцлага (ХХЯ) -ыг сум бүрт явуулж Борнуур сумын 102, Даланжаргалан сумын 94 хүнийг хамруулсан байна. Суурь судалгаанаас гарсан дүн шинжилгээн дээр үндэслэн янз бүрийн нийгмийн бүлэг, хувь хүмүүсийн төлөөллийг хэлэлцүүлэг, ярилцлагад хамруулахыг зорьсон (бэлэвсэн эмэгтэйчүүд, уурхайчид, гэрлэсэн эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд гэх мэт). ЗБУ-ыг байгалийн нөөцийн зураглал, нүүдлийн зураглал, улирлын ажлын ачаалал, оролцогч талуудын зураглал гэх мэт хамтын оролцооны стандарт арга, хэрэгслүүдийг ашиглан хийсэн. ХХЯ-ыг урьдчилан бэлтгэсэн бүтэцтэй, гэхдээ хувь хүнээс шалтгаалан өөр байж болох хүмүүсийн амьдрал, амьжиргаа, жендерийн харилцаа, байгалийн нөөцийг хүүхэд байх үеэсээ хэрхэн хүртдэг байсан, өөрчлөлтүүдийн тухай мэдэж авах зорилготой байв. Мөн орон нутгийн захиргааны ажилтнууд, зарим уул уурхайн компани, байгууллагын төлөөллүүдтэй үулзаж ярилцсан юм.

Үндэслэл

Монгол социализмын үе, ардчилсан шилжилтийн аль алинд нь оршин тогтносоор байгаа уламжлалт нүүдлийн мал аж ахуйн урт түүхтэй орон юм. Алт, жонш, цайр, төмрийн хүдэр, мөнгө, хар тугалга гэсэн голлох ашигт малтмалуудтай, бүх төрлийн хэмжээтэй уул уурхайн үйл ажиллагаа, өнцөг булан бүрт явагдаж буй. Жендерийн эрх тэгш байдлын тухай үндсэн хууль, бусад хуулиудад тусгасан, эмэгтэй хүмүүс дангаараа эсхүл гэр бүлийн гишүүдтэйгээ хамтран газрын бүртгэл хийлгэж, газар өмчилж болохыг хуулиар зөвшөөрсөн байдаг. Манай ЭГЭББ төслийн хамрагдах хоёр сумын иргэдийн яс үндэс, шашин шүтлэг ойролцоо, ихэнхдээ халх, буддын шашин шүтдэг хүмүүс юм. Аль аль нь залуучууд ихтэй, голдуу эмэгтэйчүүд нь эрэгтэйчүүдээсээ боловсролын түвшин дээгүүр байдаг. Гэхдээ, тэдний малаа хариулж байгаа хэв маяг, уул уурхай явагдаж буй хэмжээ ялгаатай, Монголын нийт эдийн засагтай холбогдож байгаа хүрээ нь мөн ялгаатай юм.

Борнуур сум Улаанбаатар хотоос хойш 115 км-ийн зайд Төв аймагт оршдог. Нийт газрын хэмжээ нь 114,687 га бөгөөд үүнээс ойролцоогоор 36,000 га нь ой, 68,000 га нь бэлчээр, 8,100 га нь тариалангийн талбай юм. 2015 оны 3-р сарын 3-ны байдлаар сумын хэмжээнд 18 уул уурхайн лиценз олгосон бөгөөд үүнээс 6 нь олборлолт, 12 нь хайгуулын лиценз юм. Борнуур сумын гол ашигт малтмалын нөөц алт юм. Борнуур сум нийт 4 багтай, Өгөөмөр, Мандал багууд сумын төвийнх харин Бичигт, Нарт нь хөдөөний багууд бөгөөд малчдын ихэнх нь амьдардаг. 2016 оны 8-р сарын 4 –ны байдлаар нийт 5,059 хүн амтай, 1,404 өрхтэй байв.

Даланжаргалан сум нь Говийн бүсийн Улаанбаатар хотоос хойш 288 км-ийн зайд Дорноговь аймагт оршдог. Нийт газрын хэмжээ нь 404,590 га бөгөөд цөл хээрийн бэлчээр зонхилсон нутаг юм. Транс-Сибирийн төмөр зам сумыг дайран өнгөрдөг, Их Нартын байгалийн нөөц газрын 44,000 га нь суманд байдаг. 2016 оны 4-р сарын 6-ны байдлаар сумын хэмжээнд 90 уул уурхайн лиценз олгосон бөгөөд үүнээс 42 нь олборлолт, 48 нь хайгуулын лиценз юм. Даланжаргалан сум нүүрс, жонш, барилгын материал, төмөр, хагас үнэт чулуу (өнгөт чулуу) зэрэг ашигт малтмалын нөөцтэй. Даланжаргалан сум нийт 5 багтай, Цомог, Олон-овоо багууд сумын төвийн илүү хотжсон, хэмжээний хувьд жижиг, харин Элдэв, Өнгөт, Бичигт нь хөдөөний, хэмжээний хувьд том багууд юм. 2016 оны 7-р сарын 28 –ны байдлаар нийт 2,641 хүн амтай, 916 өрхтэй байв.

Борнуур суманд хийсэн судалгааны үр дүн

Монгол улс 1990 оноос ардчилсан шилжилт хөдөлгөөн хийснээс хойш хотжилт, газар хувьчлал эрчимтэй явагдаж, бэлчээрийн талхагдал их болсны улмаас Борнуурын зарим иргэд уламжлалт мал аж ахуй эрхлэхээ зогсоож эрчимжсэн, хагас эрчимжсэн мал аж ахуй эрхлэх болсон. Мөн тариаланчид дунд хэмжээний тэжээл, хүнсний ногооны тариалан эрхлэх болсон. Борнуур сумын судалгаанд хамрагдсан өрхийн олонх нь мал малладаг, мөн тариа тариалдаг ба/эсхүл албан ажил эрхэлдэг өрхийн гишүүнтэй байв. Мөн судалгааны үеэр өрх бүрт гар аргаар алт олборлодог ажилтай холбоотой байсан, байгаа ядаж нэг гишүүнтэй байв. Сүүлийн үед ихэвчлэн залуучууд, ажилгүй эрэгтэй хүмүүс ажиллах болсон байна. Борнуур дахь зүүн Германы уурхайн компани ойролцоогоор 1979 өөс 1990 онуудад ажиллаж байсан бөгөөд хаагдсанаас нь хойш алтны өндөр гарцтай ордуудтай учир бусад компанийн хөрөнгө оруулалтууд, гар аргаар уурхай эрхлэх хүмүүс олширсон. Нэг компани (Гүн билэгт) 1998 аас 2012 он дуустал, нөгөө компани нь (Сентерра Голд) 2003-аас 2016 онд ажиллаж байсан боловч, ирээдүйд Борнуур суманд ямар компанийн уул уурхайн ажиллагаа явагдах нь тодорхойгүй байна. Учир нь 2009 оны “урт нэртэй хууль”- ийн хэрэгжилтийг хангах, шийдвэрлэгдээгүй асуудлууд байсаар байна.



Олон хүн уул уурхайгаас иргэд ямар нэгэн ашиг шим хүртээгүй эсхүл ажиллах боломж ч нээгдээгүй гэж мэдэгдсэн ба харин түүний оронд нутгийн байгаль орчин сүйдсэн, газарт ирэх дарамт ихэссэн гэжээ.

Эрэгтэй уурхайчдын дунд архины хамааралтай хүн ихсэж байгаа, эрүүл мэндийн асуудал үүл уурхай эрхэлж байсан, байгаа хүмүүсийн дунд их болж байгаа бөгөөд уушигны өвчнөөс болж амь насаа алдсан тохиолдлууд байна. Урьд нь хурдацтай хөгжиж байсан гар аргаар алт олборлох үйл ажиллагааны нийгэм, эдийн засгийн асуудлуудыг шийдвэрлэх гарц хайхын тулд ШХА-ын Тогтвортой бичил уурхай төслөөс 2008 онд Борнуур суманд бичил уурхай эрхлэгчдийн шүхэр байгууллагыг байгуулахад тусалсан байна. 2010 онд бичил уурхайг хуульчлах үндэслэл тавигдаж 2006 оны Ашигт малтмалын тухай хуулт, 2002 оны Газрын тухай хуульд тус тус өөрчлөлт орсон байна.

Эмэгтэйчүүд ихэнхдээ гэр орны ажил ба эрэгтэйчүүд гэрийн гадаах хүнд хүчир ажлыг хийдэг. Гэхдээ эрэгтэй, эмэгтэй хүмүүс ижилхэн ажилаа хувааж хийх нь олонтаа. Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн аль аль нь шаргуу хөдөлмөрлөдөг боловч эмэгтэйчүүд хүүхдээ асран хамгаалах, гэр орны ажил хийх зэргээр илүү хугацаа зарцуулж, илүү шахуу ажилладаг байна. Мөн эмэгтэйчүүд банкны зээл, газрын гэрчилгээ хөөцөлдөх зэрэг ажлыг хийдэг ч газрын гэрчилгээ ихэвчлэн эрэгтэй хүний нэр дээр гардаг байна. Уламжлалт ёсоор эрэгтэй хүнийг өрхийн тэргүүн гэж үздэг ч эмэгтэйчүүд өрхийн шийдвэр гаргахад чухал үүрэгтэй оролцдог. Ихэвчлэн эмэгтэй хүн ихэнх шийдвэрийг гаргадаг эсхүл хамтран гаргадаг байна. Харин мал муулах, худалдах зэрэг шийдвэрийг эрэгтэй хүмүүс гаргадаг. Эмэгтэйчүүд өрхийн санхүүг хариуцдаг, ихэнхдээ баг, сумын үүлзалтад оролцдог боловч эрэгтэйчүүд улс төрийн хамгийн өндөр эрх мэдэлтэй алба хариуцдаг байдаг.

Борнуур суманд хийсэн судалгааны ажлын хүрээнд газар, байгалийн нөөцийн талаар олон зөрчил байгааг олж илрүүлсэн. Социализмаас хойш газар ашиглалтын олон төрлийн зөрчил ерөнхийдөө өсөх хандлагатай байна. Эдгээр зөрчил нь суманд янз бүрийн өөрчлөлт болсонтой холбоотой. Борнуур суманд шилжин ирэгсэд ихэссэний улмаас газрын хомсдол, газрын төвлөрөл, суурьшлын бус газрын наймаа, байгаль орчин талхагдах зэргээр газрын дарамт улам ихэссэн. Эдгээр дарамтаас гадна Борнуур суманд гарч байгаа нийгэм-эдийн засаг, байгаль орчны хурдацтай өөрчлөлтүүд нь ядуу болон эмзэг бүлгийн хүмүүст илүү сөрөг нөлөө үзүүлж, томоохон үүрэг гүйцэтгэж байна. Энэхүү эмзэг бүлэгт өрх толгойлсон эмэгтэйтэй өрх, залуучууд болон ажилгүйчүүд багтаж байна. Учир нь тэд орон нутгийн газрын менежментэд оролцох, газар олж авахад хамгийн их бэрхшээл тулгардаг.

Сумын төвд сууцны олгох газар байхгүй, усалгаатай ногооны талбайд газар байхгүй болсон ч мөнгөтэй хүмүүс янз бүрээр ашиглах зорилготой газар худалдаж эсхүл түрээслэн авдаг болсон. Газрын гэрчилгээжүүлэлт ихэссэн, хадлангийн газрын хувьчлал их болж, сумын захиргаанаас зохицуулах оролдлого хийж байгаа ч маргаан их үүсэх болсон. Албан ёсоор газар хувьчилж байгаа үйл явцыг олон хүмүүс эрх тэгш бус гэж үздэг. Жуулчны бааз, үүл уурхайн газар, хадлангийн талбай, тариа, ногооны газрыг том том хэмжээгээр цөөн тооны чинээлэг хувь хүмүүс авсан (эзэмших эсхүл түрээсээр) гэсэн яриа байна. Харин ядуу хүмүүс ямар нэгэн хөрөнгийн гэрчилгээ, эзэмших гэрчилгээ, ашиглах гэрчилгээ авч чадахгүй байна. Газрын янз бүрийн гэрчилгээ авах үйл явц чирэгдэлтэй, хугацаа их ордог, ойлгоход хэцүү гэж хүмүүс үздэг байна. Олгогдоогүй газар байхгүй учир залуу хүмүүс өвөлжөөний газар авахад маш хэцүү байдаг бололтой. Түүнчлэн, ихэнх ахмад хүмүүс сумын кадастрийн зураглалд орсон өвөлжөөний газартай байлаа ч эзэмших гэрчилгээгээ аваагүй байна. Хүмүүс нэг л газартаа жил бүр зуншдаг учир уламжлалт эрхтэй болсон байна.

“Одоо ямар ч төрлийн газар авсан хөрөнгийн гэрчилгээ, баримт хэрэгтэй.”

(Борнуур сум, Бэлэвсэн, ахимаг насны эрэгтэй)

1990 оноос хойш хөгжсөн үүл уурхай, тухайлбал гар аргаар алт олборлох болсон нь сумын иргэдэд шинэ боломж авчирсан ч эрүүл мэнд, архидалт гээд шинэ шинэ асуудлыг бий болгож, хууль бус байсаар байгаа нь үүнийг улам бүр хурцдуулж байна. Гэвч, 2010 оноос хойш хортой химийн бодис ашиглах явдал буурч, гар аргаар уурхай эрхэлж буй хүмүүс илүү зохион байгуулалтад орж, хүчирхийлэл багассан. Мөн энэ үед орон нутгийн иргэд болон томоохон уурхайн компаниудын хоорондын харилцаа холбоо маш муу байсан, суманд үйл ажиллагаа явуулж буй компаниудын талаар нутгийн иргэдэд тэр бүр мэдээлдэггүй байсан бололтой. Мөн үүл уурхайн үйл ажиллагаа, өргөжин тэлж буй жуулчны салбар сумын усны чанар, хүртээмжид муугаар нөлөөлсөн учир малчид онцгойлон санаа зовниж байлаа. Зарим малчид сүүлийн хэдэн арван жилд суурьшлын байр байшинтай болж, хагас эрчимжсэн болон

эрчимжсэн мал аж ахуй, тариалан эрхлэх болсон зэргээр амьдрал сайжирсан гэж үзэж байгаа ч уламжлалт нүүдлийн мал аж ахуйгаас хамаардаг ихэнх хүмүүсийн хувьд амьдрал нилэнхүйдээ хэцүү болсон гэж үзэж байна. Янз бүрийн төрлийн газрыг хувьчлах явдал ихэссэнээр сумын бэлчээрийн газрыг хүртэл хашаалахад хүргэж өнө эртний уламжлалтай хамтын эзэмшлийн хэв шинжийг алдагдуулахад хүргэж, үлдсэн бэлчээрийн газар хүн, малын тоо нэмэгдсэний улмаас ихээр талхагдаж байна. Дээрх бүх өөрчлөлтүүд, хотжих хэв маяг зэрэг нь залуу хүмүүсийг мал маллах сонирхолгүй болгож нийслэл хот руу очиж ажил хайх, ахмад хүмүүсийг хөдөө үлдэхэд хүргэж байна.

Сайн ажилтай малчин өрхийн хувьд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ажил үүргийн хуваарь нэг нэгнээ нөхдөг, эмэгтэй хүмүүс шийдвэр гаргах болон санхүүгийн асуудалд чухал эрх мэдэлтэй байдаг бололтой ч Борнуурт бэлэвсэн эмэгтэйчүүд ядууралд өртөх эрсдэлтэй, эдэлбэрийн баталгаагүй байдалтай болж

“Би эхлээд тариан талбай дээр туслахаар ажилладаг байсан. Харин одоо ногоо тарих туршлагатай болсон учир өөрийн гэсэн газартай бол өөрөө тарьж чадна. Гэхдээ газар авах их хэцүү”
(Борнуур сум, дунд насны бэлэвсэн эмэгтэй)

байгаа зэрэг хэд хэдэн жишээг бид мэдэж авсан. Хэдийгээр салалт түгээмэл биш ч өрхийн тэргүүн болох нөхрийн нэр дээр газрын гэрчилгээ гаргуулдаг явдал нь асуудал дагуулах магадлалтай. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн аль аль нь албан ёсны

газар олгох үйл явцад ямар нэгэн жендерийн ялгаварлал байдаггүй гэдэгтэй санал нийлсэн ба зөвхөн чинээлэг ядуугаар нь ялгадаг гэж үзэж байна. Мөн олон эмэгтэй орон сууцны газар (бас нэлээдгүй хэд нь жижиг хэмжээний хүнсний ногооны газартай) өмчилдөг хэмээн мэдэгдсэн. Гэхдээ бэлчээрийн газар олж авахад уламжлалын дагуу эрэгтэйчүүд хоорондоо харилцан тохиролцдог учир өрх толгойлсон эмэгтэйтэй өрхүүдэд бэлчээр, зуншилгааны газар, хадлангийн газар олж авахад бэрхшээлтэй байдаг ба бусадтай маргах тохиолдолд тэд ихэвчлэн алддаг байна. Мөн бэлэвсэн эмэгтэйчүүдийн эдгээр газрын эрхийг хүндэтгэдэггүй байна. Мал маллах ажил эрэгтэй тэргүүнтэй өрхийн хийх ажил гэсэн уламжлалт нийгмийн ёс жаяг тогтсон байдаг, түүнчлэн өрх толгойлсон эмэгтэйтэй өрхүүд мал муулах, машин техник ажиллуулах зэрэг “эр хүний” ажлыг хийхийг хүсэхгүй мөн/эсхүл энэ хүнд ачааг даадаггүй байна. Өрх толгойлсон эмэгтэйтэй өрхөд тохиолдож байгаа эдгээр бүх бэрхшээл нь уул уурхайгаас шалтгаалсан эрэгтэйчүүдийн өвчлөл, эндэгдэл өндөр байгаагаас шалтгаалан, мөн ерөнхийдөө газрын хомсдол, төвлөрөл, талхагдал үүсээд байгаа нөхцөлд улам бүр хүрцдаж байна.

Даланжаргалан суманд хийсэн судалгааны үр дүн

Даланжаргалан сумын амьдрал ардчилал гарснаас хойш сүүлийн 20 гаруй жилийн туршид нэлээдгүй өөрчлөгджээ. Бүхэлдээ уламжлалт мал аж ахуй эрхэлж байсан нийгмээс уул уурхай, аж үйлдвэрийн тэсрэлттэй үялдаад нийгмийн хурдацтай өөрчлөлтүүд гарчээ. Даланжаргалан сумын голлох хоёр амьжиргааны хэлбэр бол мал маллах, албан ажил эрхлэлт юм. Суманд төрсөн уламжлалт бэлчээрийн мал аж ахуй эрхлэгчид, эдийн засаг, ажил мэргэжлээс шалтгаалан нүүж ирсэн хүмүүсийн аль аль нь амьдардаг. Уул уурхай, ялангуяа бичил уурхай эрхэлдэг хүмүүс цөөнгүй. Тариа, ногоо тариалах нь амьжиргааны гол эх үүсвэр биш. Борнууртай



адил Даланжаргалан сумын эрэгтэйчүүд голдуу гаднах хүн хүчир ажлыг нугалдаг, эмэгтэйчүүд нь гэр, байшингийн доторх ажлыг хийдэг. Эмэгтэйчүүд өрхийн шийдвэр гаргахад чухал үүрэгтэй оролцдог. Гэхдээ айл хоорондын бэлчээр, усны асуудал зэргийг зөвхөн эрэгтэй хүмүүс хоорондоо хэлэлцэн шийддэг. Энэхүү уламжлалт хөдөлмөрийн хуваарийн улмаас эмэгтэй хүн эрэгтэй хүний дэмжлэггүйгээр мал маллахад хүндрэлтэй байдаг. Иймд эрэгтэй тэргүүнтэй өрхийн амьжиргаа өрх толгойлсон эмэгтэйтэй өрхтэй харьцуулахад мал маллахаас илүү хамаардаг байна.

Даланжаргалан суманд том, дунд, жижиг хэмжээний нүүрс, жоншны уурхайн үйлдвэрлэл, төмөр, барилгын материалын олборлолт, хууль бус бичил жонш, хагас үнэт чулууны олборлолт, цементийн үйлдвэр, жонш боловсруулах үйлдвэр зэрэг байдаг. Сүүлийн хорин жилд суманд уул уурхайн хөгжил их

явагдсан. Эхлээд 1996 оны үед цөөн тооны хууль бус уурхайчид Хятадуудад жонш худалдаж эхэлсэн ч энэ тоо хэдэн мянгад хүрсэн. Учир нь энэ орлого олох боломжийг харж, Монгол орны өнцөг булан бүрээс ажилгүй иргэд ирсэн. Жижиг, дунд хэмжээтэй компаниуд 1997 оноос ажиллаж эхэлсэн, харин 1998 онд Монголын Алт Корпораци (МАК) нэртэй үндэсний компани суманд нүүрс олборлолт явуулж эхэлсэн. Албан ёсны мэдээгээр Даланжаргалан сумын нутаг дэвсгэрийн 19% уул уурхайн лицензэд байдаг байна.

1990 ээд оноос хойш орон нутагт уул уурхайн салбар хөгжиж ирснээс хойш сумын газар, байгалийн нөөцийн талаар уурхайчид малчдын хооронд, мөн малчид өөр хоорондын зөрчил, маргаан гарах нь элбэг болсон бололтой. Бидний ажлын үеэр уулзаж ярилцсан хүмүүс нийтээрээ уул уурхайгаас шалтгаалж бэлчээрийн доройтол, цэвэр усны хомсдолд орж байна гэж үзэж санал нэгдсэн юм. Хүмүүс орон нутгийн иргэдийг хангах ажлын байрны боломж муу, шороо тоостой эрүүл бус ажлын байр зэрэг уул уурхайн нийгэм болон эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл, мөн олон салаа зам үүсгэх, гадаргын болон гүний усны нөөц багасах, гүнзгий нүхэнд мал унаж үхэх зэрэг байгаль орчны асуудлуудын тухай санаа зовнисон сэтгэгдлээ хуваалцаж байлаа. Хүмүүс хууль бус бичил уурхай эрхлэгчид, бүх төрлийн хэмжээтэй уул уурхайн компаниудын аль альных нь үйл ажиллагаанд тийм ч таатай бус ханддаг ба уул уурхайгаас нутгийн иргэдийн хүртсэн ашиг шим бага гэж үздэг байна. Уул уурхайн компаниудын үйл ажиллагаа, бичил уурхай (хууль бус) эрхлэгчдийн тухай мэдлэг, мэдээлэл хомс байдгаас ийм байдалд хүрсэн байх магадлалтай. Мөн уул уурхайн компаниудын уурхайн газрыг нөхөн сэргээх, нутгийн байгаль орчин, малчдын бэлчээрийн газрын эдэлбэрийн эрхийг хамгаалахад орон нутгийн засаг захиргаанаас иргэдтэй зөвлөлдөж, хяналт тавьж санаачлагатай оролцох ёстой гэдгийг ерөнхийдөө хүмүүс шаардаж байгааг бид анзаарсан юм. Харин нөгөө талаар орон нутгийн иргэд уул уурхай, үйлдвэрийн ажилчдад мах, хүнсний ногоо борлуулах, дэлгүүр ажиллуулах, үйлчилгээ явуулах зах зээлтэй болсон. Мөн зарим талаар тэдэнд уул уурхайн салбарт ажил эрхлэх боломж нээгдсэн.

Даланжаргалан суманд төвийн багуудын хашаа, байшингийн газрын өмчлөл, хөдөөгийн багуудын өвөлжөө, хаваржааны эзэмших гэрчилгээ олголт ихэвчлэн явагддаг. Борнуур сумтай адилаар ихэвчлэн эмэгтэйчүүд газар авах, гэрчилгээ авах ажлыг хөөцөлддөг, гэхдээ ихэнх гэрчилгээ, баримтууд эрэгтэй хүний нэр дээр гардаг. Газар авах албан үйл явц ээдрээтэй, хугацаа их шаарддаг, ялангуяа, хол амьдарч байгаа өрхийн хувьд. Харин зарим хүмүүс нь хүн бүрт эрх тэгш хандаггүй гэж үздэг байна. Ерөнхийдөө өвөлжөө, хаваржааны газар олгох үйл явц хашаа, байшингийн газар олгох үйл явцаас илүү ээдрээтэй, хүртээмжгүй харагдаж байсан, зарим үед хэд хэдэн айл өрх нэг өвөлжөөний газар дээр өргөдөл гаргах гэх мэт. Ялангуяа, өрх толгойлсон эмэгтэйтэй өрхийг эрэгтэй хүмүүс давамгайлсан малчдын хувьд тоож авч үздэггүй санагдсан.

“Хэрэв ганц бие эмэгтэй хэн нэгний гэрийн ойролцоо буух эсхүл хэн нэгний усны нөөцийн ойр ирвэл тэр айл нь хөөнө.”
(Даланжаргалан сум, гэрлэсэн эрэгтэй)

Даланжаргалан дахь уул уурхайн хөгжил, тэлэлт нь сайн бэлчээрийн хомсдол, маргаанд хүргэж байгаа гэж иргэд үздэг, бидний ажигласнаар бэлчээрийн маргаан хэвийн зүйл болж байна. Орон сууц, өвөлжөө, хаваржааны газарт хувийн өмчлөлийн эрх олгож газар эдэлбэрийг албан ёсоор баталгаажуулсны улмаас хашаажуулах практик элбэгшиж, улирлын нүүдэл зэрэгцэж бүүрсан байна. Хөдөөгийн багуудын ихэнх өрх өвөлжөө, түүний орчмын бэлчээрээ хамгаалахын тулд жилийн түрш өвөлжөөндөө амьдардаг, эсхүл ойрхон нүүдэг болсон байна. Цаашлаад малчдын амьдрал илүү суурин тал руугаа болж байгаа энэ хандлага нутгийн бэлчээрийн тогтвортой байдалд дарамт учруулж байна. Малчдын хэдэн үеэрээ нутаглан ирсэн бэлчээрийн уламжлалт эдэлбэрийн эрхийг баталгаатай болгох зорилгоор өвөлжөө, хаваржааны газрын гэрчилгээ олгох (эзэмших гэрчилгээ) ажил эхэлсэн хэдий ч малчдын дунд газраа алдах, гэрчилгээгүй газартай хоцрох вий гэсэн айдсаас үүдэлтэй газрын маргаан ихэссэн. Ингэснээр малчдын нүүдэл багасаж, уламжлалт газрын менежментийн практик өөрчлөгдөхөд нөлөөлж байгаа бөгөөд үүний үр дагавар одоогоор тодорхой болоогүй байна.

Даланжаргалан сумын нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлын өөрчлөлт бэлчээрийн мал аж ахуйн амьдралын хэв маяг, өрх болон нутгийн иргэдийн дунд жендерийн харилцаа өөрчлөгдөхөд нөлөөлсөн.

Уламжлалт нүүдлээс холдож бэлчээрээ хувьдаа хаших хандлагатай болж буй бэлчээрийн менежментийн өөрчлөлтүүд малчин айл өрхийн эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хооронд өрхийн түвшинд гарч буй өөрчлөлтүүдтэй давхцаж байна. Хамгийн наад захын жишээ нь салангид амьдардаг айл өрхүүд буюу хүүхдээ боловсрол эзэмшүүлэхийн тулд жилийн ихэнх цагт хосууд тусдаа амьдардаг явдал юм.

Сумын төв дээр хүүхдүүдтэйгээ байдаг эмэгтэйчүүд мэдээлэлд илүү ойртож, бие даасан байдлаа нэмэгдүүлж, зарим тохиолдолд албан ажил эрхлэх, арилжаа наймаа хийж байхад эрэгтэйчүүд өвөлжөөндөө хоцорч гэр орны ажил хийж,

“Айл өрх нэг газраа бүх улирлын турш амьдардаггүй уламжлалтай, Өнөө үед нүүх газаргүй болсон юм хойно энэ уламжлал өөрчлөгдөж байна даа.”

(Даланжаргалан сум, Малчдын бүлгийн гэрлэсэн эмэгтэй)

улам бүх асуудалтай болж байгаа мал маллах ажил хийдэг. Энэ амьдралын шинэ хэв маяг сумын төв дээр гишүүн нь амьдарч газрын гэрчилгээгээ хөөцөлдөх, зах зээлд ойртох боломжтой болох зэргээр айл өрхөд бүхэлдээ ашиг тустай байдаг ч жинхэнэ үр дагавар нь тодорхой болоогүй байна. Нөгөө талаар “хуурамч” салалт хийх нь ихсэж, эхнэр нөхөр хоёр зэргэлдээх хоёр суманд тус тусдаа бүртгэл хийлгэж, “салсан” эмэгтэй өөрийн нэр дээр газар авах боломжтой болж, бэлчээрийн талбайгаа (өвөлжөөний ойролцоох бэлчээр ашиглах эрхтэй газраа томсгох) томсгож байна. Ингэснээр эмэгтэйчүүд өөрсдийн нэр дээр өвөлжөө авах боломж олгож байгаа ч гэр бүлийн харилцаанд дарамт үүсгэж, яваандаа жинхэнэ салалтад хүргэж болзошгүй.

Гэвч, социализмын үед өсч өндийж, ажиллаж байсантай нь харьцуулахад илүү хэцүү эдийн засгийн орчинд өрхийн үйлдвэрлэл эрхлэхийн тулд шургуу ажиллаж байгаа гэрлэсэн хосуудад бие биедээ итгэх итгэл их байдаг бололтой. Гэсэн хэдий ч ерөнхийдөө эмэгтэйчүүд ямар нэгэн байдлаар, ялангуяа зарим бүлгийн эмэгтэйчүүдийн (эрэгтэйчүүдийн) байдал дор байгаа нь ажиглагдаж байв.

Нэгдсэн дүгнэлт

Борнуур, Даланжаргалан сумууд олон талаараа ялгаатай. Борнуур сум Улаанбаатар хоттой хамаагүй ойр, амьжиргааны эх үүсвэр олон, социализмын үеэс тариалан эрхлэлт орон нутгийн эдийн засагт чухал үүрэгтэй байсан. Даланжаргалан сумын хувьд иргэд нь илүү уламжлалт мал аж ахуй эрхэлдэг, гэхдээ уул уурхайн үйл ажиллагааны цар хүрээ (холбогдох аж үйлдвэржилт) хамаагүй том бөгөөд малчдын амьжиргаанд илүү аюул занал учруулж буй байдалтай байна.

Хоёр сумын аль аль нь эдийн засаг социализмаас зах зээлд шилжсэнээр их өөрчлөгдсөн. Газар хувьчлал явагдаж, олдоц муутай болсон. Иргэдийн дунд газраа алдахвий гэсэн айдсаас үүдэлтэй хашаалах явдал аль алинд нь түгээмэл болсноор улирлын нүүдэл хийхэд хүндрэл ихтэй болсон. Нүүдэл багасаж, ерөнхийдөө хүн ам, малын тоо өсч байгаатай холбоотойгоор хүмүүс бэлчээрийн талхагдал ихэсч байна гэж үздэг болсон ба хоёр сумын аль алинд нь бэлчээрийн маргаан их гарах болжээ (Борнуур сумын хувьд хадлангийн газартай холбоотой маргаан). Уул уурхайн үйл ажиллагааны байгальд үзүүлэх нөлөөлөл эдгээр асуудлуудыг улам хурцатгаж байгаа бөгөөд ялангуяа, Даланжаргалан сумын хувьд илүү их яригдсан юм.

Хоёр сумын аль алин дээр нь уул уурхайн лицензүүд, үйл ажиллагааны тухай мэдээлэл тун хомс байдаг ба уул уурхайн компаниуд, иргэдийн хоорондын хамтын ажиллагаа хязгаарлагдмал байдалтай байсан. Уул уурхайн компаниуд орон нутгийн иргэдэд тодорхой тооны ажлын байр гаргасан ч хоёр сумын аль

“Нутгийн иргэд бизнесийнхэнтэй ажиллах мэдлэггүй, мөн нутгийн улс төртэй зохицох мэдлэг байхгүй, бид нутгийн иргэдтэй уулзаж, зөвлөлдөх оролдлого хийдэг ч тэд бидэнтэй хэрхэн ажиллахаа мэддэггүй.”

(Даланжаргалан сум, уул уурхайн компанийн төлөөлөл)

алинд нь хүмүүс гар аргаар уурхай эрхлэх ажилд илүү оролцдог. Борнуур сумын хувьд эдийн засаг нээлттэй болж эхлэнгүүт хууль бус гар аргаар алт олборлох ажил эхэлсэн бол Даланжаргалан сумын хувьд хууль ёсны (лицензтэй жижиг хэмжээний) болон хууль бус гар аргаар уул уурхай эрхэлж байгаа хүмүүсийн аль аль нь байгаль орчны томоохон асуудлуудыг үүсгэж байна гэж харагдсан. Хууль ёсны гар аргаар алт, жонш олборлох ажлыг гэр бүлийн гишүүд хамтдаа хийдэг, харин хууль бусаар хагас үнэт

чулуу түүх ажлыг ихэвчлэн эмэгтэй хүмүүс хийдэг байна. Хоёр сумын аль алинд нь гар аргаар уул уурхай эрхлэх ажил маш аюултайд тооцогддог ба хүмүүс амьдрахын эрхээр хийдэг байна.

Хоёр суманд социализмаас зах зээлийн эдийн засагт шилжсэн явдал, уул уурхайн хөгжлийн аль аль нь жендерийн хувьд үр дагавартай байсан. Эмэгтэйчүүд орон нутагт болон өрх гэрийн хэмжээнд шийдвэр

“Хэрэв би гэрчилгээгээ өөрийн нэр дээр гаргуулна гэж зүтгэвэл манай нөхөр намайг ирээдүйд салах гэж байна гэж бодно.”
(Даланжаргалан сум, гэрлэсэн эмэгтэй)

гаргахад чухал үүрэгтэй оролцдог ч (мөн тэдний илүү өндөр боловсролтой байгаатай холбоотой) уламжлалт жендерийн хэм хэмжээ хэвээр хадгалагдсаар байна. Ерөнхийдөө, мал маллахыг эрх хүний ажил гэж үздэг учир бэлэвсэн, салсан эмэгтэй хүмүүст үргэлжлүүлэн малаа

маллахад хүндрэлтэй байдаг. Бэлчээрийн маргаан нэмэгдэж байгаатай холбоотойгоор өрх толгойлсон эмэгтэйтэй малчин өрхийг хүндэтгэж үзэх магадлал тун бага байна. Мөн хоёр суманд, газрыг ихэнхдээ өрхийн тэргүүн нь эр хүн учир түүний нэр дээр байх ёстой гэж үзэж гэрчилгээ олгодог байна. Гэхдээ зарим эмэгтэйчүүд эзэмших гэрчилгээтэй эсхүл гэрчилгээн дээр хамтран эзэмшигчээр бүртгэгдсэн байна. Газар ховордож байгаа үед газрын гэрчилгээгүй эмэгтэй хүмүүс бэлэвсэрсэн эсхүл салсан тохиолдолд бэрхшээлтэй тулгарч магадгүй байна. Борнуур сумын хувьд салалтын хэмжээ бага ч Даланжаргалан сумын янз бүрийн шалтгаанаар хувьд ихсэх хандлагатай байна. Өрхүүдийн салангид амьдарч байгаа явдал зарим талаар давуу талтай, боломж гаргаж байгаа ч гэр бүлийн амьдралд дарамт үзүүлж, салалтыг нэмэгдүүлэх магадлалтай. Мөн хуурамч салалт хийж байгаа малчин өрхүүдийн хувьд бас адилхан асуудал үүсэх магадлалтай юм.

Манай судалгаагаар Даланжаргалан, Борнуур сумын аль алинд нь уламжлалт нүүдлийн мал аж ахуй аюулд өртөөд байна гэж гарч байна. Зах зээлийн эдийн засагт шилжсэн, Даланжаргалан суманд уул уурхайн үйл ажиллагаа их болсон, Борнуур суманд газрыг олон зорилгоор өрсөн ашиглах болсон зэрэг нь бүгд бэлчээрийн талхагдлыг ихэсгэж байна гэж хүмүүс үзэхэд хүргэж, малчдын нүүдлийг багасгаж байна. Хоёр сумын аль алинд нь гадны болон дотоодын хүчин зүйлсийн аль аль нь малчдын амьжиргааг маш ихээр эрсдэлд оруулж байна. Нэг талаас төрийн бодлого бэлчээрийн мал аж ахуйн амьдралын хэв маягыг дэмжихгүй байгаа юм шиг, харин оронд нь эрчимжсэн мал аж ахуй болон тариалангийн салбарыг дэмжиж уул уурхай, аялал жуулчлал, фермийн аж ахуйн хөрөнгө оруулалтад зориулж том хэмжээний газрыг олгосон мэт харагдаж байна. Нөгөө талаас ихэнхийг нь гадны санаачилгаар хийж буй хөрөнгө оруулалтууд сумын бэлчээр, ус, ойн нөөцийн чанар, хэмжээ, мөн орон нутгийн хүмүүсийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна гэж үзэж байсан. Даланжаргалан суманд уул уурхайн цар хүрээ, хэмжээ өссөн явдал, газар эдэлбэрийг албан ёсны болгож эхэлсэнтэй нийлээд сөрөг үр дагавар (хүсээгүй) гарч, уламжлалт мал аж ахуйн хэв маяг, нийгэм, жендерийн харилцааны харилцан хоорондоо уялдаатай өөрчлөлтүүдийг бий болгож байна.

Борнуур сумын малчид хагас эрчимжсэн мал аж ахуй эрхлэх болж орлогын өөр эх үүсвэртэй (мөн төрөөс дэмжиж байгаа) болж байна. Даланжаргалан суманд айл өрхүүд өөрчлөлтөд дасан зохицохын тулд олон янзын арга хэмжээ авч, амьдарлын хэв маягаа өөрчилж байгаа нь урт хугацаанд нийгмийн хувьд тогтворгүй байх магадлалтай. Мөн залуу хүмүүс малчин болохыг хүсэхгүй болж, Улаанбаатарт ажил хайхаар их явж байгаа нь Борнуур суманд илүү ажиглагдсан. Эмэгтэй хүмүүс боловсрол өндөртэй учир өрсөлдөх чадвар сайн эдийн засагт байр сууриа олж байхад эрэгтэй хүмүүс архинд донтох, хүчирхийлэл гаргах зэргээр гэр бүлийн харилцааг салгахад хувь нэмэр оруулж болзошгүй. Түүнчлэн зөвхөн өрх толгойлсон эмэгтэйтэй өрх гэлтгүй залуу малчид, тэр дундаа гэр бүлээсээ хол амьдарч байгаа эрэгтэй хүмүүсийг эмзэг бүлэг гэж үзэж болохоор байна.

Мал маллах болон тариалан эрхлэх аль альных нь тал дээр газар авахад хэцүү болсон, уул уурхайн үйл ажиллагаа аюултай, жендерийн үүргийн талаарх уламжлалт, нийгмийн хэв маяг хэвээр байсаар байгаа зэргээс харахад хоёр суманд эмзэг бүлгийн хүмүүст тохиромжтой амьжиргааны эерэг боломжууд юу вэ гэдэг асуулт хэвээр үлдэж байна. Жижиг бизнесүүд, албан ажил эрхлэлт нь чухал гарц гэж харагдаж байгаа ч бүгд хийх боломжгүй.

Харин, газар, байгалийн нөөцийн эдэлбэрийн засаглалыг сайжруулснаар илүү шийдлүүд гарах ёстой. Борнууртерөнхийдөө газар болон байгалийн нөөцийн талаар шийдвэр гаргахад Борнуурын бүх иргэд

илүү оролцож, ялангуяа бэлчээрийн газрын талаар ядуу хүмүүс тэр дотроо эмэгтэй малчид, бэлэвсэн эмэгтэйчүүд, өвчтэй бас ахимаг насны ядуу хүмүүсийг оролцуулах хэрэгтэй байгаа гэдэг нь тодорхой байна. Ингэснээр эдгээр эмзэг бүлгийн хүмүүс урт хугацааны ужиг ядууралд орох, эдэлбэрийн баталгаа нь алдагдахаас хамгаална. Үүний адилаар Даланжаргалан суманд жендер, уул уурхайн харилцааны асуудлуудыг зохицуулахын тулд илүү далайцтайгаар мэдээлэл солилцох арга зам олох, газар болон байгалийн нөөцийн засаглал, менежментэд нутгийн бүх хүмүүсийн, ялангуяа сумын ядуувтар, илүү эмзэг бүлгийн хүмүүсийн оролцоог нэмэгдүүлэх нь чухал байна.

ЭГЭЭББ төслийн голлох үр дүнгүүд

1. Ерөнхийдөө, уул уурхайн компаниудад тавих хяналтыг илүү санаачлагатай болгож, газрыг нөхөн сэргээх, нутгийн байгаль орчин, хүмүүсийн эрүүл мэнд, малчдын бэлчээрийн эдэлбэрийн эрхийг хамгаалах хэрэгтэй байгаа шаардлагыг орон нутгийн засаг захиргаанд тавьж байна.
2. Уул уурхай, газрын тухай мэдээллийг илүү өргөнөөр солилцох, хуваалцах арга зам бий болгох шаардлагатай.
3. Газар, байгалийн баялгийн тухай, ялангуяа бэлчээрийн газрын тухай шийдвэр гаргах, засаглал, менежментийг явуулахад бүх хүмүүсийг илүү өргөнөөр оролцуулах шаардлага тавигдаж байна.

Үндсэн санал

Манай судалгаагаар тодорхойлогдсон олон асуудлыг хоёр сумын аль алинд нь цогц арга хэмжээ авч шийдвэрлэх боломжтой. Энэ нь олон янзын газар ашиглагчдын хоорондын зөрчлийг бууруулахын тулд олон талт оролцогч талуудыг хамруулж харилцан яриа, хэлэлцүүлэг өрнүүлэх юм.

Багын хурлуудад олон янзын газар ашиглагчдыг оролцуулж орон нутгийн газар эдэлбэрийн засаглал, газрын менежменттэй холбоотой асуудлуудыг хэлэлцэж, хамтын оролцооны аргаар хамтдаа шийдлийг хайх хэрэгтэй юм. Ингэхдээ дараах зүйлсийг харгалзаж үзэх хэрэгтэй:

- эрэгтэй эмэгтэй, баян ядуу, ахмад залуу гээд бүх хүмүүсийн оролцоог сайн хангахад анхаарах-хамгийн эмзэг бүлгийн хүмүүсийг шийдвэр гаргахад оролцуулах, үүнд бэлэвсэн, өрх толгойлсон эмэгтэйтэй өрх багтана;
- малчид, эрчимжсэн, хагас эрчимжсэн фермийн аж ахуй эрхлэгчид, тариаланчид, ногоо тарьдаг хүмүүс, ойн нөхөрлөлүүд, ой ашиглагчид, гар аргаар уул уурхай эрхлэгчид бусад уурхайн ажилтнууд, нутгийн засаг захиргааны төлөөллүүд, том, дунд, жижиг лицензтэй уул уурхайн компаниудын төлөөллүүд, байгууллагуудыг оролцуулах хэрэгтэй.

Ингэснээр мэдээлэл хуваалцах боломжтой болж, хууль, дүрэм журмыг ойлгож, олон янзын нөөц ашиглагчдын дүрэм, журмыг тогтоож, ямар өөрчлөлт хийх ёстойг тодорхойлох боломжтой болно. Мөн манай судалгаанд оролцсон олон хүний бүтээлч саналыг дэлгэрүүлэн хэлэлцэж болох ба сумын тогтвортой хөгжлийн төлөө бүх хүний оролцоог хангах хэрэгтэй юм.

ХТБХ нь 2006 онд байгуулагдсан Монголын ТББ бөгөөд орон нутгийн иргэд, иргэний нийгмийн байгууллагуудад дэмжлэг үзүүлэх замаар байгалийн нөөцийг хамгаалах үйлсэд хувь нэмэр оруулах зорилготой бөгөөд жендерийн эрх тэгш байдал, нийгмийн эмзэг бүлгүүдийн асуудалд анхаарал хандуулдаг. Мокоро нь Англи улсад төвтэй ашгийн бус байгууллага бөгөөд газар, байгалийн нөөцийн засаглалын олон талт асуудлуудын хүрээнд мэргэжлийн зөвлөгөө өгдөг.

Мокоро болон ЭГЭЭББ төслийн тухай нэмэлт мэдээлэл, мөн төслийн тухай цаг үеийн мэдээлэл, нийтлэлүүдийг авахыг хүсвэл манай цахим бүртгэлд хамрагдаарай. www.mokoro.co.uk/wolts эсхүл edaley@mokoro.co.uk хаягаар имэйл бичээрэй.

ХТБХ байгууллагын дэлгэрэнгүй мэдээллийг авах хаяг. nyansanjav@yahoo.com.

ЭГЭЭББ төслийн Монголын баг - Э.Далей, Я.Нарангэрэл, К.Ланз, Н.Лхамдулам, З.Дрисколл, Б.Сувд, Б.Мөнхтүвшин, Ж.Грахам, Р.Эрдэнэбат. Энэхүү судалгааны санал, дүгнэлтийн хураангуй нь бидний хамтын ажиллагааны үр дүн юм. Текстүүд © ЭГЭЭББ баг. Бүх фото зураг © ЭГЭЭББ баг.